



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/195

Ховд

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалт, аймгийн Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь дуусч үргэлжлүүлэн ажиллах нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон Рашаант, Бугат, Буянт, Жаргалан, Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төв, Манхан, Эрдэнэбүрэн сумын эмийн эргэлтийн сан, Мөст сумын эрүүл мэндийн төвийн тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээр тус тус сунгасугай.

2. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах нөхцөл шаардлагыг ханган ажиллаж буй Үенч сумын хилийн 0130 дугаар ангийн Эрүүл мэндийн төвд уламжлалын болон өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээний чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсугай.

3. Тусгай зөвшөөрлийн эрх авахаар ирүүлсэн төсөл, хөтөлбөр нь дэмжигдэж, үйл ажиллагаа явуулах нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон Алтай сумын “Аньс” эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар шинээр олгосугай.

4. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө сунгуулсан, нэмэлт өөрчлөлт оруулсан, шинээр олгосон байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга Д.Мягмарсүрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

3400 01 0065
Zah A/195 Kh